

# ОРОН СУУЦНЫ ҮНИЙН ИНДЕКС (2017-02 САР)


Монголбанк, “Тэнхлэг зууч” компанитай хамтран 2017 оны 02 дугаар сарын “Орон сууцны үнийн индекс”-ийг тооцоолон, танилцуулж байна. Энэхүү тооцоо, судалгаанд тухайн сард зах зээлд нийлүүлэгдсэн шинэ, хуучин 4,978 орон сууцны үнийг хамруулсан болно.

## ОРОН СУУЦНЫ ҮНИЙН ИНДЕКС

2017 оны 02 дугаар сарын байдлаар орон сууцны үнийн индекс өмнөх сараас 2.8%-иар өссөн бол өнгөрсөн оны мөн үеэс 4.4%-иар буурчээ.


Тухайн сард зах зээлд нийлүүлэгдсэн шинэ, хуучин орон сууцны үнэ өссөн нь орон сууцны үнийн индекс бага зэрэг өсөхөд нөлөөлжээ.

ЗУРАГ 1: УЛААНБААТАР ХОТЫН ОРОН СУУЦНЫ ҮНИЙН ИНДЕКС /2013.01=1.00/



2013 оны 1 дүгээр сараас эхлэн орон сууцны үнийн индексийг тооцсон бөгөөд орон сууцны үнийн жилийн өсөлт 2014 оны 3 дугаар сард хамгийн өндөр буюу 23.7%-тай гарсан байна. 2014 оны 12 дугаар сараас орон сууцны үнэ (өмнөх оны мөн үетэй харьцуулахад) буурч эхэлсэн бөгөөд орон сууцны үнийн бууралт үргэлжилсэн хэвээр байна.

ЗУРАГ 2: ОРОН СУУЦНЫ ҮНИЙН ИНДЕКСИЙН ЖИЛИЙН ӨСӨЛТ /2013.01=1.00/



Жишээ: БЗД-ийн “Энканто” таунд 2016 оны 02 дугаар сард 1 м<sup>2</sup> дундаж үнэ 2,799,000 төгрөг байсан бол 2017 оны 02 дугаар сарын байдлаар 2,575,000 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 8.0%-иар буурсан байна.


## 1. Шинэ орон сууцны үнэ<sup>1</sup>

Шинэ орон сууцны 1м.кв дундаж үнэ нь 2017 оны 02 дугаар сарын байдлаар 2,051,000 төгрөг болж өмнөх сараас 0.21 хувиар өнгөрсөн оны мөн үеэс 0.43 хувиар тус тус өссөн байна.

### ШИНЭ ОРОН СУУЦНЫ 1 М.КВ-ИЙН ДУНДАЖ ҮНЭ /2017.02/


|                        |                  |
|------------------------|------------------|
| Орон сууцны дундаж үнэ | 2,051,000 төгрөг |
| Жилийн өсөлтийн хувь   | +0.21%           |
| Сарын өсөлтийн хувь    | +0.43%           |
| Хамгийн өндөр үнэтэй   | Сүхбаатар        |
| Хамгийн бага үнэтэй    | Сонгино хайрхан  |

ЗУРАГ 3: ШИНЭ ОРОН СУУЦНЫ 1 М.КВ ДУНДАЖ ҮНЭ /сар,төгрөг/



Сүхбаатар дүүрэгт шинэ орон сууцны 1м.кв-ийн дундаж үнэ хамгийн өндөр байгаа бол Сонгино хайрхан дүүрэгт хамгийн бага байна.

ЗУРАГ 4: ШИНЭ ОРОН СУУЦНЫ 1 М.КВ ДУНДАЖ ҮНЭ /сар,төгрөг/




## 2. Хуучин орон сууцны үнэ – 2 өрөө байр<sup>2</sup>

Хуучин 2 өрөө байрны дундаж үнэ<sup>3</sup> нь 2017 оны 02 дугаар сарын байдлаар 73,271,000 төгрөг болж өмнөх сараас 0.70 хувиар өссөн бол өнгөрсөн оны мөн үеэс 9.59 хувиар буурсан байна.

### ХУУЧИН 2 ӨРӨӨ БАЙРНЫ ДУНДАЖ ҮНЭ /2017.02/


|                        |                   |
|------------------------|-------------------|
| Орон сууцны дундаж үнэ | 73,271,000 төгрөг |
| Жилийн өсөлтийн хувь   | -9.59%            |
| Сарын өсөлтийн хувь    | +0.70%            |
| Хамгийн өндөр үнэтэй   | Сүхбаатар         |
| Хамгийн бага үнэтэй    | Сонгино хайрхан   |

ЗУРАГ 5: ХУУЧИН 2 ӨРӨӨ БАЙРНЫ ДУНДАЖ ҮНЭ /сар,төгрөг/



Сүхбаатар дүүрэгт хуучин 2 өрөө байрны дундаж үнэ хамгийн өндөр байгаа бол Сонгино хайрхан дүүрэгт хамгийн бага байна.

ЗУРАГ 6: ХУУЧИН 2 ӨРӨӨ БАЙРНЫ ДУНДАЖ ҮНЭ, ДҮҮРЭГ /сар,төгрөг/



Эх үүсвэр: “Тэнхлэг зууч” компанийн сар бүрийн тооцоолол

<sup>1</sup> Байрны гэрчилгээ нь гараагүй бол шинэ орон суул.

<sup>2</sup> Иргэдийн хувьд 2 өрөө байр худалдан авах боломж нь 3-4 өрөө байр худалдан авах боломжоос харьцангуй их.

<sup>3</sup> 2000 оноос өмнөх хуучин орон сууцны үнэ (дүүргүүдийн дундаж үнэ)